

МОНГОЛ МАЛ” ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Мал аж ахуйн салбарыг хөгжүүлэх талаар төрөөс олон бодлогын баримт бичиг боловсруулан гаргасан боловч түүний хэргэжилт шаардлагын хэмжээнд хүрэхгүй байгаагаас тус салбарын цаашдын тогтвортой хөгжлийг хангах зорилгоор Улсын их хурлаас 2010 онд “Монгол мал” үндэсний хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж эхэлсэн.

Уг хөтөлбөрийн гол зорилго нь мал бүртгэлжүүлэлтийн ажил бөгөөд өнөөдрийн байдлаар нийслэлд 125.0 мянган мал ээмэгжүүлэн мэдээллийн санд бүртгэгдэхээс энэ ажил дөнгөж 45.2 хувьтай байгаа талаар аудитын байгууллага шалгалт хийж, хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй байна гэсэн дүгнэлт гаргасан.

Хөтөлбөрийн хэрэгжилт нийслэлийн хэмжээнд хангалтгүй байгаа нь эрчимжсэн мал аж ахуйн талаар гаргасан бодлогын баримт бичиг байхгүй, хөтөлбөр хэрэгжих хууль, эрх зүйн орчин бүрдээгүй, нэгдсэн төлөвлөгөө боловсруулаагүй, төрийн захиргааны байгууллагууд зохих хяналтыг хэрэгжүүлээгүй зэрэгтэй холбоотой юм.

Мөн нийслэлийн төсөвт энэ хөтөлбөрт зарцуулагдах төсөв тусгагдаагүй, хөтөлбөрийг хэрэгжүүлэх анхан шатны нэгж байдаггүй зэрэг нь хөтөлбөрийн хэрэгжилтэнд муугаар нөлөөлсөн.

Сүүлийн жилүүдэд иргэдийн хот руу чиглэсэн их нүүдлийн нөлөөгөөр нийслэлийн малын тоо 329,0 мянган толгойд хүрсний улмаас бэлчээрийн даац тав дахин хэтэрч, хот орчмын бэлчээр ихээр талхлагдаж, бэлчээрийн мал аж ахуйг эрхлэх боломж багасч байгаа учраас нийслэлийн хэмжээнд бэлчээрийн газар нутгийг бүсчлэн, эрчимжсэн аж ахуйн чиглэлээр хөгжүүлэх нь чухал асуудлын нэг болоод байна.

Мөн нийслэлд уламжлалт мал аж ахуй эрхэлж, нийслэлийн хүн амын хүнсний хэрэгцээг бүрэн хангах боломжгүй бөгөөд харин эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлж, жилийн дөрвөн улиралд тасралтгүй үйл ажиллагаа явуулсны үр дүнд хүн амын хүнсний хэрэглээний гол бүтээгдэхүүн болох мах, махан, сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэгцээг хангах бүрэн боломжтой юм.

Нийслэлд 2013 оны байдлаар 1,3 сая гаруй хүн амьдарч байгаа бөгөөд нийт сүү, сүүн бүтээгдэхүүний 50 орчим хувийг, мах, махан бүтээгдэхүүний 5 гаруй хувийг, өндөгний хэрэглээний 60 гаруй хувийг дотоодын үйлдвэрлэгчдээс нийлүүлж байна.

Нийслэлийн мал аж ахуйг эрчимжсэн байдлаар төрөлжүүлэн хөгжүүлж, малчдын хамтын хөдөлмөр эрхлэх, хоршоо байгуулах эрх зүйн орчинг бүрдүүлэн, нийслэлийн малыг бүртгэлжүүлж, бүртгэлээр дамжуулан хүнсний аюулгүй байдалд хяналт тавин, хотын хүн амын хүнсний бүтээгдэхүүнийг экологийн цэвэр, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан нөхцөлд бэлтгэж, технологийн өндөр түвшинд боловсруулан нийлүүлэх бодлого чиглэлийг боловсруулж, хэрэгжүүлэх шаардлага зайлшгүй урган гарч байна.

Иймээс Нийслэлийн Үйлдвэр хөдөө аж ахуйн газар нь “Монгол мал” дэд хөтөлбөрийг боловсруулж, батлуулан, хэрэгжүүлэхээр төлөвлөн энэ ажлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Мал эмнэлэг, үржлийн газар, Нийслэлийн мал эмнэлэгийн газар болон Нийслэлийн мэргэжлийн хяналтын газруудаас санал авч уг дэд хөтөлбөрт тусгасан болно.